

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Зүшийн Галсан	Дугаар	L200
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	Өргөн сум
Төрсөн газар	Сайхан дулаан сум	Төрсөн он	1921 он
Ажил мэргэжил	Хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Олон хүрээ	Сүм хийдийн дугаар	ДГСД 104
Одоогийн сүм хийд	Өлгий хийд	Сүм хийдийн дугаар	ДГМН 095
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Олон хүрээ

За тэгэхээр Галсан гуай ,та аль хүрээ хийдэд шавилан сууж байсан хүн бэ?

Галсан: За Олон хүрээ , Олон хүрээнд гэдэг юмүү, одоо Амармэндийн хүрээ гэдэг юм ш дээ.Одоо энэ манай Бир вангийн хошууны ганц төв, том хийд нь байсан юм. За энэ хийдэд би нэг 7 настайдаа байсан. 15-тай гарч байсан юм даа

Гантулга: За та хэдэн онд төрсөн хүн бэ?

Галсан: 21 он. 1921 онд төрсөн юм

Гантулга: Олон хүрээний өөр түүх байна уу?

Галсан: Түүх гэхээр чинь одоо...

Гантулга: Тэр дуган дацангуудын нэрийг та мэдэх үү?

Галсан: Дуган дацангууд ч яахав дээ, одоо хэд байдгийг нь мэднэ ээ

Гантулга: Зүгээр төвд нэрүүд байдаг шүү дээ тийм дацан ийм дацан гээд?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: Байхгүй ээ

Гантулга: Тэр нэрийг нь бол мэдэхгүй байна уу?

Галсан: Мэдэхгүй байна

Гантулга: Олон хүрээ л гэж явдаг байсан уу ер нь?

Галсан: Тийм Олон хүрээ л гэж

Гантулга: Өөр нэр байхгүй юу?

Галсан: Олон хүрээ л гэдэг юм даа

Гантулга: Гандантэгчилэн гэдэг шиг нэр байгаагүй юу?

Галсан: Өө одоо саяхан л санаанд орж байсан

Гантулга: За яахав ээ, санахаараа хэлээрэй. Хэдий үед байгуулагдсан хийд вэ, ямар хүн үүсгэн байгуулсан хийд вэ?

Галсан: За даа ёстой мэдэхгүй дээ энийг чинь одоо. Одоо энэ Сумьяа гэдэг чинь манай энд/ ярилцлага түр завсарлав/ 78 ,79-тэйдөө нас барсан гэж үздэг юм байна лээ.Тэр үед ер нь бидэнд ярьж байсныг нь санаад байдаг юм. Тэр бас надад бидэнд ярьж байсан нь цаг нь бас ирдэг юм байна шүү

Гантулга: Та хэдтэй байсан бэ ,тэр үед?

Галсан: За хүү минь одоо тэр үед ч нэг 16, 17-той л байсан байх даа.Тэр хүн тэгээд ярьж байсан юм. Би 13-тай хийдэд мөргөж байсан.Тэгсэн чинь харин түр зуурын , хурал гээд тарчихжээ.Тэгж тэр нөхөр л ярьж байсан юм даа. Тэр одоо хэдэн онд ярьж байсан бэ гэхлээр одоо...37, 38 оны үед. 38, 39 оны үед ярьж байсан юм. 70-тай, 80 ч шахажбайсан байхаа би одоо ерөөсөө..Тэгэхээр тэр бол тэр хүүхдийг 13-тай байхад энэ Сумьяагийн хийд, 13-тай байхад ирээд мөргөөд явж байхад энэ хийд байж байсан.Тэгж ярьж байсан

Гантулга: Тэгэхэд л байж байсан гэхээр нэлээн эртний хийд байх нь ээ?

Галсан:Нэлээн эртний хийд .Тэрнээс хойш одоо хүртэл бодоод байхаар би ...За нэг 380 хүрээгүй байгаа л юм байна даа.Тийм л хийд байж дээ

Гантулга: Хуучин аль хошууны нутаг дэвсгэрийн хүрээ байв аа, энэ газар чинь?

Галсан:Тэр одоо Бир вангийн л хүрээ...

Гантулга: Бир вангийн л хүрээ байсан уу?

Галсан: Нэг болвол ерөөсөө... Амгалантын хийд гэдэг юм .Зөв

Гантулга: Аан, Амгалантын хийд .Энэ нь эргэн тойрон уулан дотор байна уу, цулгай газар байна уу?

Галсан: Ямар ий?

Гантулга:Одоо энэ Амгалантын хийд?

Галсан:За мартчихаж...өө уултай шүү

Гантулга:Араараа уултай юу?

Галсан:Араараа уултай ,урдуураа мод дагуулж байдаг.Энэ нь асар их .Тэгээд тэрний цаана уултай ,дахиж уултай. .Тэгээд дахиж уул.. дандаа уул шүү

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ойр ойрхон уултай?

Галсан: Тийм ойр ойрхон уултай

Гантулга: Уулан дотор л байх нь ?

Галсан: Уулын дунд нь байгаа юм

Гантулга: Ус нь хаана нь байдаг юм?

Галсан: Өө тэр тууриа дагаад л . Өмнө нь бол мал уудаг ус, араараа бол лам нарын уудаг ,тахилын ус байдаг.Мал уудаг тийм ус байдаг юм,юм л бол их мал орж тэндээс нь бүх мал уудаг,ард нь бол тахил, лам нарын тэр цам манзны бас л элбэг ус байдаг

Гантулга:Ер нь энэ лам нарын тэр тахидаг уул овоо байсан уу?

Галсан:Байна. Одоо ингээд энэ Хийморийн овоо гээд...Тэр баруун хойнох шовгор овоо , одоо хүртэл харагдана

Гантулга: За өөр , энэ тахилгатай овоо? Олон хүрэнээс тахидаг байсан?

Галсан: Олон хүрээ чинь энэ Баянбулгийг тахидаг газар.Жил болгон аймаг аймгаараа ээлжилж тахина.Энэ жил өмнө аймаг , одоо баруун аймаг тэгээд хойшоо гээд...5 аймаг ээлжилж тахидаг байсан.Жил болгон Баянбулгийг тахидаг газар байсан юм.Баянбулаг бол одоо очиж чадахгүй биз дээ, чаддаггүй гэж би тэгдэг юм.Ингэж цангаж байхад бол тэр Баянбулагт 3 хоногт бороо орохгүй байна гэж байхгүй.Заавал ордог.

Гантулга: Яаж тахидаг байсан юм бол , тахилганд нь та очиж байв уу?

Галсан:Үзсэн ,Би чинь жоохон хүүхэд морь унаад л... тэгээд тэр хавиар чинь тоглоод л айлуудын зассан тавагтай чихрээс шүүрээд л

Гантулга: Морь уралдаж бөх барилдана аа?

Галсан: Өө их наадна.Олон хүрээ л тахидаг . Ганжуур манжуур авчраад л, олон тэмээ ирнэ, 10-аад ачаатай тэмээ ирнэ?

Гантулга:Олон хүрээний гол шүтээн нь цогчин дуган нь, гол шүтээн нь юу байв?

Галсан: Үгүй ээ мэдэхгүй юм даа. Одоо их бурхныг л тэр хүрээний аймгаас цогчин дугандаа аваачиж тахидаг байсан.Ямар одоо бурхан багш байсан юмуу,өөр одоо Их бурхан багш байсан юмуу мэдэхгүй.Нэг бурхан багширхуу маягийн их том бурхан л авчирч, бид 3-аас ч том тийм бурхан л авчирч тахидаг байсан.Тэр үедээ одоо бурхан багш олдоогүй байлгүй дээ

Гантулга: Шарын хийд байсан уу?

Галсан: Шарын хийд байсан

Гантулга: Тэнд чинь хичнээн лам хувиргатай байсан бэ?

Галсан: Аан ?

Гантулга: Хичнээн лам хуврагатай байсан бэ?

Галсан: Хэд билээ дээ цөөхөн л лам байсан юм. Яг хэд байсныг нь би яаж мэдэхэв

Гантулга:Лам нар нь голдуу Мэргэн вангийн хошууны лам, шавь байсан уу?Өөр албан газраас ирдэг байсан юмуу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: Бараг л тийм байсан байхаа

Гантулга: Өөр одоо ойролцоо сүм хийдээс лам нар ирдэг байсан уу?

Галсан: Хурал энэ тэрээр бол ирдэг байсан юмаа

Гантулга: Хаанаас?

Галсан: Өлгийгөөс. Оndoо хошуунаас ирж байсныг би мэдэхгүй юм

Гантулга: Ойр хавьд нь байдаг, 40, 50 км-т харилцаа холбоотой байдаг, лам нар нь ирж очдог?

Галсан: тийм юм ер нь бол болоо л байх. Үгүй тэр Хонжтой ямар байсан юм бэ дээ. Жон эд нар тэнд байдаг байсан/ярилцлага түр завсарлав/Гавжийн дамжаа барих гээд л...Аграмбын, за аграмбанд ч гаднаас хүн ирээгүй. Гавж болох гээд Домбо гавж холоос зорьж ирж байсан байхаа. Чойрт сурдаг ,тэнд чинь Домбо гавж.

Гантулга: Сайн ч орлого ордог байсан уу?

Галсан: Аа нэлээн догь байдаг байсан байх

Гантулга: Аграмбын дамжаа, домын дамжаа аль алиг нь барьдаг байсан бэ?

Галсан: Домын дамжаа бариад, гавжийн дамжаа бариад, тэгээд дараа нь аграмбын дамжаа барсан юм

Гантулга: Хичнээн хүн барьдаг байсан ,нэг удаадаа?

Галсан: Өө одоо тоолоод бүтэхгүй ,олон лам. Чойрт чинь одоо гавжийн барина гээд , гавжийн дамжаа босгох гээд бараг царцдаг байхаа. Их уддаг. Жилд хоёр удаа

Гантулга: Жилд хоёр удаа барина?

Галсан: Хавар , намар хоёр. Хөдөө гарч барина. Олон хоног болно ,тэр сүм дуган эд нараа хуваагдаж барьчихаад, тэр улсууд нь .Тэгээд л Янгын голдбарина. Янгаас цааш...одоо Янгын зүүн талд.Тэгээд л Цагаанд , Зүүн цагаанд тэр үед чинь. Янга хавьцаа , тэгээд л тэрүүгээр чинь хурдаг, хурал номууд нь

Гантулга: Том хутагт хувилгаан гэж байсан уу, ер нь Олон хийдийн эзэн нь ямар лам байсан бэ?Тэргүүн лам, хамба лам нь?

Галсан:Тэр хамба нь одоо халагдаж солигдоод л байдаг байсан юм.Сүүлийн үед одоо тэр Даржаацэрэн гэж лам сүүлийн үед байсан юм.За тэгээд одоо юу мартаж дуусчээ, мартаж дуусч.Хамбууд чинь олон шүү дээ.Аа харин цэнд нь бол олонгүй ээ/ярилцлага түр завсарлав/ ...Тэгээд л гол юунд нь суудаг байсан юм

Гантулга:Хуралд ирээгүй нь суухгүй?

Галсан: Тийм

Гантулга:Том эрдэмтэн ,ринбүүчий лам нар байсан уу?Хутагт хувилгаан,тийм хувилгаан ийм хийдээс?

Галсан: Хувилгаан...Бор хувилгаан гэж байсан.Тэр чинь одоо ч мартаад өнгөрсөн хүн байхаа би чинь, өвгөн болсон хойно нь л лав очиж сурдаг байсан юм.Хөдөө нутгаар л нутагладаг Бор хувилгаан гэж , энүүгээр энэ тал хонгор нутгаар л нутагладаг.Хөдөөний айлын нэг баараггүй хүн л байсан юм ,Бор хувилгаан гэж

Гантулга: Зөндөө л нэртэй лам нар, маарамбууд байсан биз дээ хийддээ?

Галсан : Тийм, лам нар ч олон байсан л даа

Гантулга: Төвд Энэтхэгээс ирсэн эрдэмтэн лам нар?



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: За яахав... Одоо чинь. За тэгээд Хүрээ аймаг байлаа.Баруун аймаг гээд ,Баруун Зурдах гээд аймаг байлаа.Тэгээд Чин аймаг, аймгуудаа гүйцээчихье.Тэгээд Минжүүр аймаг ,тэгээд зүүн аймаг , Зүүн Зурдах. Одоо болсон байхаа. Ингээд 5 аймаг байна.За дацангуудаас ..

Гантулга: Цогчин дуган?

Галсан: Тийм цогчин дуган чинь гол дуган

Гантулга: Чойр дуган?

Галсан: Тийм, Цогчин ,Чойр ,Мамба, Жүд.Дүйнхор гээд ийм л байна даа

Гантулга:Хэдэн суваргатай байсан юм?

Галсан: Аа суварга нэг л суварга байсан

Гантулга: Энэ одоо цогчин дугануудыг юугаар барьдаг байсан бэ, ямар хэлбэрээр одоо дугуй хэлбэртэй байсан уу, дөрвөлжин хэлбэртэй байсан уу?

Галсан: Ганцхан нь дугуй байсан .Зүүн зурдах гээд ганцхан дугуй тэг хэлбэртэй байсан.Бусад нь дандаа дөрвөлжин.Чойр дацан хоёр бол том оо?

Гантулга: Та аль дацангийн хүн байсан, дацанд сууж амусан уу?

Галсан: Үгүй би ер нь дацанд сууж амжаагүй.Зүгээр л одоо Жилаа хийдэд байж байгаад тэгээд л

Гантулга:Тэр Готов Гочоогийн сүм гэж ямар учиртай сүм байсан ,шүтээнийх нь сүм байсан гэлүү?

Галсан: Тэр бол одоо Мэргэн вангийн хошууны ганц ... Мэргэн вангийн хошууны Гочоо гэдэг хүн бол хошууныхаа төв юу нь л байлаа.Тэр Гочоо гэж баруун газар явж нэг бурхан залжээ.Тэр хүн тэр бурхныг тахь гэж наашаа явуулжээ.Тэрнээс ихтэй. За энэ бурхнаа газар битгий тавиарай.Газар хүргэж болохгүй шүү.Дандаа юман дээр тавьж байгаарай гэж хэлээ.д. Тэгээд наашаа авч явж байгаад нэг хадтай гуугаар газар битгий тавиарай гэсэн , энэ хад юм чинь хадан дээр тавьчихъя гээд хадан дээл аваад тавьчихсан.Бурхнаа тавьчихаад тэгээд хэсэг байж байгаад бурхнаа аваад явах гэтэл наалдцан байсан . Наалдцан салдаггүй.Тэр өөрөө бол мундаг хүчтэй бурхан байгаа юм.Тэгээд за одоо яахав газар битгий тавиарай гэсэн, хадан дээр тавьчихсан тэгээд дуртай нь цаашаа яваг, дургүй нь эндээ хоцор гээд тэр бас их том хүн байсан.Тэгээд нөгөө бурхныг чинь цээжин хэсгийг нь аваад явсан

Гантулга: Аа цээж нь ирсэн бурхан юм байна?

Галсан:Тэгээд цээжийг нь авчраад хийддээ ирээд дархчуудаар үлдсэн хэсгийг нь хийлгэсэн юм гэсэн .Тэр Гочоо гэдэг хүн нь одоо тэр Гочоо гэж бурхных нь нэр байдаг юм уу.Гочоо гэдэг нь лав тэр авчирсан хүнийх нь нэр.Тэгээд тэр чинь манай энэ хийдийн ганц шүтээн нь байж байгаад алга болчихсон байгаа юм дуулахнээ.Энэ чинь юу юм л даа одоо айлын хуралдаа Гочоог авчирч ирсэн гэж би нэг дуулсан.Тэгээд тэр Гочоо чинь алга болчихгүй юу яасан юм бүү мэд.Тэгээд л байж байсан .Нэг өдөр харин тэр Очирваань бурхныг хүн тахичихсан байсан...Хай тэгээд тэр манай Олон хүрээний Очирваань бурхан алга болцон.Тэгээд л тэр нэг гарыг нь талыг аваад явцан байсан. Тэгээд тэрийг чинь би авъя гээд Гочоо лам аваад тэр гарыг нь хийлгээд.Тэгээд тэр бурханд

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

залаад байж байсан, тэгээд өгөхгүй байсан юмаа манай энд.Тэгээд одоо тэр Гочоо гэдэг нь аймгийн хуралд сууж байгаад...Очиж чадаагүй л дээ, очих юм бол тэр бурхнаа танина даа

Гантулга: Ном барладаг газар байсан уу?

Галсан: Өө бас байсан юм гэнэ лээ.Гэхдээ тун бага ном...Ганжуур данжуур бол үгүй байсан юм. Зүгээр жижиг номнууд л

Гантулга:Олон хүрээний тэг зураг гэж байсан уу?

Галсан:Өө байдаг байлгүй, байдаг, юмуу үгүй юмуу .Мэдэхгүй

Гантулга: Одоо тийм юм байхгүй юу?

Галсан:Байхгүй ээ

Гантулга: Ямар аймаг ямар ном хурдаг байсныг та мэдэхгүй юу?

Галсан:Чойр л байх даа одоо .Чойрт чинь л ном хураад л гавжийн дамжаа энэ тэр бариад л, орчин үеийн номуудыг нь очиж үзнэ.

Гантулга: Жүд нь ямар байсан юм бол?

Галсан: Жүд нь бол аграмбын чиглэлийн гавжаас дээш мэдлэгтэй , том лам нарын л.Аграмб болох улсууд л одоо жүдэд ордог. Тийм улсууд л

Гантулга: Маарамба?

Галсан: Айн?

Галсан: Маарамба , мамба дацан нь?

Галсан: Мамба дацан нь . за мамба чинь одоо энэ оточ улсуудын л газар байсан даа. Их бага отчууд мамбад л их тахидаг байсан даа. Намайг хүртэл мамбад суулгана гэж бас хэлдэг байсан юм

Гантулга: Аймгуудын дуган дацанд юу хурдаг байсан юм ?

Галсан: Өө тэр аль аймаг нь ямар сахиустай байсан юм тэрийгээ голлоод л .Жишээлбэл:Хүрээ аймаг гэхэд л одоо юу Жамсран тахидаг, улаан шахуу.Одоо миний хэдэн мэддэг номнууд маань тэнд л байдаг байсан юм даа

Гантулга: Та аль аймагт нь байсан юм?

Галсан: Аа би Хүрээ аймгийн хүн байсан юм.Тэгээд одоо Улаан шахуу Жамсранг тахидаг

Гантулга:Цогчин дуганд очдог байсан уу ,та?

Галсан: Өө очно. Цогчинд ордоггүй хүн гэж байхгүй байсан

Гантулга: Аа бүгд нийлээд л ордог?

Галсан: Намар бол хүн бүгд л очно.Бусад дацангууд дахь улсууд очно

Гантулга: Цогчинд ер нь юу юу хурдаг байсан юм?

Галсан: Аа Цогчинд хурдаг юм нь одоо ер нь ...

Гантулга:Өдөр бүрийн юмуу, одоо сар бүрийн юмуу сардаа шинийн найманд ч юмуу одоо?

Галсан: 10 хавьцаа ер нь ...хурахгүй юм байхгүй дээ.Ганжуур эд нарыг чинь одоо Цогчинд л хурна шүү дээ

Гантулга: Жилд болдог том хурлууд нь, одоо жишээлбэл цагаан сарын хурал?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: Өө одоо шинэ хүүхдийн хурал гээд л хорин хэднээр ч билээ, цагаан сарын 15 хүртэл одоо шинэ орсон жилийн хурал гээд л одоо биднүүс чинь хуралдана .Чойр бол жил болгон хуралдана

Гантулга:Цам гардаг байсан уу?

Галсан: Гарна аа. Майдар эргээд л тэгээд дараа нь цам гардаг

Гантулга: Майдар эргэхээр цам гарна?

Галсан: Тийм

Гантулга: Ойр ойрхон гардаг байсан уу, майдар цам нь?

Галсан:Ойрхон

Гантулга: Майдар нь эргэчихээд?

Галсан: Тийм майдар нь урдаар эргэнэ

Гантулга: Нэг өдөр эргэнэ?

Галсан: Тийм

Гантулга: Яаж эргэдэг байсан юм?

Галсан:Өө тэгээд л цогчиндоо байж байгаад л урагшаагаа уулын өвөр дээр очоод л тэгээд л нэг том майдар эргээд л тэгээд л баруун уулан дээр авираад л, тэгээд л дараа нь зүүн уулан дээр авираад л тэгээд бүтэн өдрийг яваад л тэгээд л дуусч байгаа юм

Гантулга: Майдраа юун дээр залдаг байсан бэ, зүгээр хүмүүс өргөөд явдаг байсан уу?

Галсан:Аа их хөөрхөн тийм модон цүнх хийдэг байсан юм. Урд талд нь ногоон морьтой халзан залаатай ногоон морины ...Их ч гоё морьтой тэгээд жолоо цулбуур хамаг юмтай. Тэгээд тэрнийгээ майдар бурхны доогуур ордог байхдаа бодоход, тэгээд тэрийг чинь думаана

Гантулга: Хэдэн хүн?

Галсан: Өө олон хүн. 4, 5 лам байсан юм. Тэгээд думнахын хажуугаар тэр 4 дугуйг нь эргүүлж явна

Гантулга: Тэгээд хүрээ хүртэл бол өргөжинө?

Галсан: Аа тэр чинь бүгдээрээ явна.

Гантулга:Тэгээд дараа нь хэдэн хоногийн дараа танай хийдэд ирсэн юм?

Галсан: Их уддаггүй байхаа. Ойрхон гардаг байсан юм

Гантулга: Цам нь том цам гардаг байсан уу?

Галсан: Аа том цам гарна. Өнөө 10 догшид чинь цөмөөрөө гарна шүү дээ

Гантулга:Өөр ямар маарамбууд гардаг байсан юм ?

Галсан: Аан?

Гантулга: Өөр ямар маарамбууд гардаг байсан юм, 10 догшидоос гадна?

Галсан: Одоо 10 догшид чиг л байсан.Янз янзын юмнууд байсан Тэр үед чинь одоо Монхон юу юу гэсэн хэдэн юм байсан юм

Гантулга: Лам нар нь ирдэг үү?



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: Лам нар нь байсан юм

Гантулга: Яаж ирдэг байсан юм?

Галсан: Үүрээр зарим нь модны хөндийгөөр хүрээд ирнэ .Их олон бололтой лам нар ирнэ, заримдаа цөөхөн 2, 3 ч лам нар ирнэ. Тэгээд үүрэх нь үүрээд л...Тэгээд л янз бүрийн ханиад томуу, тахал өвчин гарсан чиг л ганжуур эргэдэг...

Гантулга: Цагаан сарын хурлаар ямар ямар ном хурдаг байсан юм, хэдий үеэс эхэлсэн юм?

Галсан: Өө ном бол одоо олон ном л уншиж байдаг

Гантулга: Сарын хэднээс эхлээд ямар ямар ном уншаад тэгээд сор залдаг байсан уу?

Галсан: Сор залдаг байсан.

Гантулга: Хэдий үед нь залдаг байсан юм?

Галсан:Сорыг чинь цам эргээд одоо цам дууссанаас эхэлж л сор зална

Гантулга: Цагаан сараар бас сор зална?

Галсан: Цагаан сараар бас зална. Битүүнд ер нь бас цогчин сүмийнхээ урд сор залдаг байсан юм.Аа тэр цам гараад сор залах бол бүр хол газар аваачаад шатаадаг тийм байсан юм ?

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдөр , Богд ламын ламын дүйчэн өдөр их хурал хурдаг байсан уу?

Галсан: Их хурал хурдаг байсан Ерөөл өргөнө.

Гантулга: Ерөөл?

Галсан: Тийм, ерөөл.Намар.Багачуул болвол гэсэр болвол хурна. Тэгээд дандаа гэсэр гэлэнгүүд ....Дандаа гэлэнгүүд тахиж шүтдэг...дандаа гэлэнчүүд

Гантулга:Нүгмээ тахидаг байсан уу?

Галсан: Дандаа тахидаг байсан.

Гантулга:Яаж тахидаг байсан?

Галсан: 3 хоногоор 5 хоногоор тахидаг байсан

Гантулга: Өөр тийм наадам хийдэг, шашны баяр хуралдаанд ордог байсан уу, том наадам, бөх барилдаж морь уралддаг?

Галсан:Өө тэр наадам, за тэр .../ярилцлага түр завсарлав/ ...наадам болж байсан юм даа. Нээх сүртэй юм бол болохгүй . Морь мал уралдана.Бөх барилдана

Гантулга:Энэ дуганууд нь их олон дуган баригдаж байсан гэсэн тиймээ.Дээвэр нь ер нь дөрвөлжин дээвэртэй байсан уу, цүм оройтой байсан уу?

Галсан: Цүм оройтой байсан. Дандаа цүм оройтой байсан , тэр засварын юу чинь

Гантулга:Хийдэд бол нэг л дугуй сүм байсан тиймээ, энэ сүм байгуулахад бол нэг л дугуй модон сүм байсан гэсэн тиймээ?

Галсан: Тийм нэг л модон дугуй сүм байсан юм. Зүүн Зурдах л гэж ганц дугуй сүм байсан юм.Одоо маарамба болж байсан, тэгээд гавж болно.Тэгээд аграмб болно

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Олон хоног олон хоног сурдаг байсан уу?

Галсан: Аа дамжаа олон хоног өнгөрнө. Дамжаанд чинь одоо гавж болж байгаа хүн хэд байхуу, аграмб болж байгаа хүн хэд байхуу, нэг л хүний нэг өдөр

Гантулга: Нэг хүнд л ер нь нэг өдөр ?

Галсан: За 10 хүн болвол нэг 10 өдөр , 20 хүн болвол нэг 20 өдөр болно

Гантулга: Олон хүрээ хийдтэй холбоотой байсан уу?

Галсан: Аа олон байсан байх. Өлгийн , Хамжийн ...юу юу билээ дээ байз .Лав л 7 байсан даа

Гантулга: Өлгий хийд ,Хамжийн хийдтэй их зузаан холбоотой байсан уу?Лам нар нь ирж очдог?Ном хурдаг байсан уу, хоорондоо?

Галсан: Үгүй одоо энэ манайхаас нэг ямар гээч нь билээ...Өлгий маанин хуралд явж байсан.Гайгүй очдог байсан юмаа. Эргэл мөргөл хийхээр ч юмуу

Гантулга: Төвд рүү Энэтхэг рүү ном сурахаар лам нар явдаг байсан уу?Танай хийдээс?

Галсан: За сүүлийн үед бараг байхгүй болсон байхаа.Уг нь явдаг л байсан юм гэнэлээ

Гантулга: Олон хүрээ олон жастай байсан уу?

Галсан: Айн?

Гантулга: Олон жастай байсан уу?

Галсан: Бүгдээрээ тийм байсан юм

Гантулга: Тэр дуган дацан аймгууд бүгд жастай?

Галса: Дацангууд их жастай.

Гантулга: Олон малтай байсан уу?

Галсан: Өө малтай байсан

Галсан:Дуган дацан аймаг тэр хавиараа л ?

Галсан: Тийм ,аймаг аймгаараа тэгээд л

Гантулга:Байшин саванд суудаг хүн байсан уу?

Галсан:Багадуу байшинтай хүмүүс олон байсан..За овоо хэдэн гэр байсан . 10-аас ч илүү л байсан байх

Гантулга: Зог, дүгчин чойдон улсууд байсан уу, галч?

Галсан: Ганц хоёр галч нар бол байсан . Тэднүүд бол байнга суудаггүй

Гантулга: За дүгжин , чойдон ?

Галсан: Аан.

Гантулга: Хандмаа нар байсан уу, эмэгтэй лам нар?

Галсан: Эмэгтэй лам нар байгаагүй ээ.Миний мэдэх тэр ганцхан л хүн байсан .Нансанчойжил гэж .Сүүлийн үед л орж ирсэн хүн юм гэнэ лээ

Гантулга: Өглөө босоод орой унтах хүртлээ юу хийдэг байсан бэ, нэг өдрөө ярьж өгөөч?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: Нэг өдөр ийм л байх даа .За тэгээд аймгийнхаа хуралд орно, жисаа бүрээс цогчиноосоо.Тэгээд орой болгон жисаа хурал хурна.Тэгээд хажуугаар нь бас юм хум идэх юм даа, бас биднуус чинь

Гантулга: Том хурлын үеэр ирэх үү , байнга ингээд ирж байх үү?

Галсан: Хурал болгоноор ирнэ. Голцуу л ирнэ дээ.

Гантулга: Тэгээд л том хурал дууссахаар л явцгаачихна ?

Галсан: Аа тэгнэ.

Гантулга: Худалдаа наймаа зах зээлийн газар байсан үү?

Галсан: Байгаагүй , зах зээл юу ч байгаагүй

Гантулга: Хятад лам нар?

Галсан: Байхгүй ээ, дээр үедээ байсан юм гэнэ лээ. Миний үед лав байгаагүй

Гантулга: Хийд хэдэн онд хаагдсан бэ?/ярилцлага түр завсарлав/ ... оны үед хаагдсан байна тиймүү?

Галсан: Хаагдах үед нь ямар хүмүүс ирж хааж байсан юм бол?

Галсан: Мэдэхгүй

Гантулга: Мэдэхгүй юу , та хүрээндээр?

Галсан: Өө тэр зохион байгуулагч нь гээд нэг хүн байсан юм даа. Тэр засгаас томилогдсон гээд...

Гантулга: Хийд бүр дээр тийм хүн суурилдаг байсан юмуу?

Галсан: Үгүй. Олон хүрэн дээр л ганцхан байсан

Гантулга: Хийд хаагдсаны дараа лам нарыг нь яасан бэ?

Галсан: Ай даа намайг гардаг жил 2, 3 том лам баригдаж. Тэгээд хойтон нь тэрнээс хойш 2, 3-аар нь 2, 3-аар түүгээд гарсан юм гэнэ лээ. Тэгээд л тэрнээс болоод л ер нь нүүгээд орсон юм гэсэн. Тэрийг бимэдэхгүй л дээ Дуулсан юм. Тэгээд нүүж чадахгүй гэсэн тэгээд за тэгээд л байхгүй

Гантулга: Сүм хийдийн барилга байшинг тэр дор нь нураасан уу, яасан?

Галсан: Мэдэхгүй

Гантулга: Та ер нь хар болсноос хойш энэ хийд дээрээ буцаж очоогүй юу?

Галсан: Буцаж очоогүй

Гантулга: Хэдэн жил очоогүй вэ, ер нь?

Галсан: Өө олон жил болж байна. Тэгээд хаяцан юм. Тэгээд сүүлд бүр нэг нутаг усаа очиж үзэх юмсан. Зориуд нэг, тэр бүгд чинь дандаа нутаг...

Гантулга: Судар ном бурхан тахилыг нь яасан юм бол?

Галсан: Хэн мэдэхэв, одоо цогчин дуганы өмнө нэг хотгор байсан юм. Битүүн шинийн нэг том мод байдаг. Тэр модны өмнө нь нэг их том нүх байдаг. Тэрүүн дотор тэр нэг Битүүн шинийнхээ том цамыг шатаасан юм. Ийм том нүх байсан юм . Тэгээд л Очирваанийг нь түлсэн юм гэдэг шив дээ. Тэгж л дуулдсан

Гантулга: Та одоо сүм хийд хаагдахаас жилийн өмнө хар болсон. Тэгээд та юу хийж байсан бэ, ямар ажил хийж байсан , сургуульд сурсан үү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсан: Сургуулиас хэтэрчихсэн гээд аваагүй дээ.Тэгээд л манай эх намайг аваад мал дээр гарсан. Сургууль нас хэтэрсэн гээд аваагүй.Тэгээд л одоо яахав дээ мал малласан аядаад л, ан гөрөө хийдэг хүн хэн байна тэрнийг л дагаад явна

Гантулга: Та одоо үзэж байсан номнуудаа мартчихсан уу?

Галсан: Байгаа , ганц нэг юм

Гантулга: Үе үе шивнэдэг үү ?

Галсан: Өө хааяа бас хойно урд нь оруулаад л хэлдэг юм

Гантулга: Шавилж сууж байсан хийдийнхээ түүхийг ярьж өгсөн таньд баярлалаа

Галсан: Одоо яахав дээ энэ тэр мэдэх юмаа хэлж өгөхөд . Зарим зарим юмыг одоо мэдэхгүй санахгүй болж байна шүү

Гантулга: За баярлалаа